

Д. Пүрэв

**ХЯТАДЫН МАОИСТ УДИРДЛАГААС ТӨВД ОРНЫГ  
ЦЭРЭГЖҮҮЛЖ, ЗЭРГЭЛДЭЭ ОРНУУДЫГ НЬ ЭЗЛЭН  
ТҮРЭМГИЙЛЭХ БОДЛОГО ЯВУУЛЖ БАЙГАА НЬ**

1949 оны ардын хувьсгалын дараах Хятадад болж өнгөрсөн, одоо ч үргэлжилсээр буй бүх хэрэг явдал, түүний дотор мөн үндэстний асуудлыг ХКН-ын дотор илэрч гарсан, нэг талаас марксист, нөгөө талаас маоист чиг шугамуудын хоорондын тэмцэлтэй нягт холбон үзэх хэрэгтэй юм.

Одоо үед их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй маоист бодлогын мөн чанар БНХАУ-ын автономит районуудын уугуул ард түмний талаар явуулж байгаа бодлогод улам тод томруун илэрч байна.

Ардын хувьсгалыг хэрэгжүүлэх тактик, стратеги, улс оронд социализмын эдийн засгийн үндсийг тавих, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнтэй харилцах зэрэг чухал зангилаа асуудлуудаар ХКН-ын түүхийн анхны үед марксистуудын чиг шугам давамгайлж байсан билээ.

40-өөд оны эцэс гэхэд бүрэлдэн тогтсон энэхүү нааштай чиг бодлогыг ХКН-ын VIII их хурал албан ёсоор баталсан билээ. Гэвч үндэстний асуудал түүний дотор тухайлбал Төвдийн асуудлаар ХКН-ын дотор ардын хувьсгалын ялалтын дараахи анхны жилүүдэд ч гэсэн их хан үндэстний дээрэнгүй үзэл давамгайлан улам газар авч байсныг анхаарах хэрэгтэй юм. 1949 оны 9-р сард Бүх Хятадын Улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлгөөнөөр «хамтын программ» нэртэйгээр батлагдсан баримт бичигт үндэстнүүдийн өөртөө засан тохинох эрхийн талаар огт дурдаагүйгээр үл барам улмаар 1950 онд хятадын цэрэг Төвдөд цөмрөн орж 1951 онд «Төвдийг тайван замаар чөлөөлөх тухай» хэлэлцээрт Төвдийн орон нутгийн засгийн газарт тулган шаардаж гарын үсэг зуруулсан байдлаас ч тодорхой юм.

ХКН-ын VIII их хурал их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй үзэлд шүүмжлэлтэй хандсан нь сайшаалтай боловч, Төвдийг хүчээр эзэлснээр илэрсэн маоист түрэмгийлэх бодлогод цохилт өгөөгүй нь харамсалтай.

ХКН-ын доторхи маоист удирдлагын их гүрний дээрэнгүй бодлого үндэстний асуудлыг шийдвэрлэх чадваргүй байснаас Төвдөд үндэстний асуудал өнөөдөр ч гэсэн шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Хятадад явагдсан улс төрийн янз бүрийн кампани нэн түрүүн Хятад дахь «соёлын хувьсгал» гэгчийн уршгаар Төвдийн орон нутгийн хууль ёсны засаг захиргааны байгууллагууд устгагдаж оронд нь цэргийнхэн зонхилсон «хувьсгалт хороод» гэгчийг байгуулсан билээ.

Тэдгээр «хувьсгалт хороод» нь Төвдийг хятадын түүхий эдийн эх сурвалж, түүнтэй хөрш зэргэлдээ орнуудын эсрэг Бээжингээс явуулах эзлэн түрэмгийлэх бодлогын түшиц газар болгон их хан үндэстний үндсэрхэх дээрэнгүй бодлогын ашиг сонирхолд бүрэн үйлчлүүлж байна. Ийнхүү маогийнхан Төвдийн автономит районыг үнэн хэрэг дээрээ хятадууд зонхилсон цэргийн онцгой бүс болгожээ. Өнөөдөр Бээжин Төвд болон үндэстний бусад районуудыг гадагш эзлэн түрэмгийлэх зорилгодоо зохицуулан нийгэм эдийн засгийн амьдралыг нь цэрэгжүүлэх арга хэмжээг эрчимтэй явуулж байна.

Төвдийн автономит район байгуулагдсаны 10 жилийн ойгоор, Хуа Гофэн дайнд бэлтгэх, «батлан хамгаалах» хүчин чадлыг бэхжүүлэхэд Төвдийг стратегийн онцгой ач холбогдолтой «баруун өмнөд хилийн цайз»<sup>1</sup> гэж нэрлэжээ. Өнөөдөр Төвд хятадын цэргийн захиргааны хатуу хяналтын дор байна. Бээжингээс Төвдийг цэрэгжүүлж байгаа нь Төвдийн ард түмний аж байдалд муугаар нөлөөлж байна. Одоо Төвдийн хөдөлмөрийн чадвартай бүх хүн түүний дотор эмэгтэйчүүд «өрхийн цэрэгт» алба заавал хаах үүрэгтэй байна. Төвдөд явуулсан цэрэгжүүлэх бодлогын уршгаар төвдийн ард түмний амьдралын төвшин 1950 оныхтой харьцуулахад үлэмжхэн буурлаа гэж Энэтхэгийн олон нийтийн зүтгэлтэн Ш. Бхушан бичжээ.<sup>2</sup> Бээжингийн эрх баригчдаас Азид явуулж байгаа эзлэн түрэмгийлэх бодлогоо хэрэгжүүлэхийн тулд энэ орны хүн хүч, байгалийн баялгийг шавхан ашиглах замаар стратегийн олон төрлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа нь төвдийн эдийн засаг, үндэсний соёлын хөгжилтөд ихээхэн саад тотгор болж байна. Тэд олон зуун жилийн уламжлалт төвдийн нийгмийн евөрмөц системийг маоистуудын цэрэг хүнд суртлын дэглэмээр аль хэдийн сольжээ.

1950 оны дунд үеэс эхлэн Бээжингийн удирдагчид Өмнөд Азийн орнуудын талаар өөрийн булаан эзлэх зорилгоо хэрэгжүүлэхийн үүднээс Төвдийн уугуул хүн амыг хүчээр хятадчилах энэ автономит районыг цэрэгжүүлэх бодлогыг хослуулан явуулж Төвдөд их хан үндэстний үндсэрхэх дээрэнгүй бодлогыг илэрхий хэрэгжүүлж эхлэсэн билээ. Бүр 50-иад оны сүүлчээс эхлэн Хятадын маоист удирдлага энх тайвнаар зэрэгцэн орших «Панча Шила»-гийн зарчмаас илт ухрах болсон юм. 1959 онд Хятад Энэтхэг-хятадын уламжлалт хил дээр будлиан үүсгэж улмаар зэвсэгт халдлага хийснээр хятад-энэтхэгийн хилийн районд түгшүүртэй байдал буй болсон юм. 1962 онд Энэтхэгийн эсрэг хийсэн зэвсэгт түрэмгийллээр Хятад Кашмир дахь Ладакхийн районы 36000 хавтгай дөрвөлжин км нутгийг булаан эзлэсэн юм.

Өнөөдөр Төвдийн автономит районы бараг бүх нутаг 20000 км урт стратегийн засмал замаар хөндлөн гулд холбогдсон байна. Мөн БНХАУ-ын төв районууд Лхасын хооронд стратегийн төмөр зам тавих нүсэр ажил хийгдэж байна. Төвдийн автономит районы нутагт агаарын цэргийн болон пуужинт-цөмийн, явган цэргийн 13 бааз ажиллаж байна.

Төвдийн нутагт байрласан ХАЧА-ийн 350000 гаруй цэрэг хэдэн зуун мянган өрхийн цэрэг, төвдчүүдийн оршин тогтнохынхоо төлөө идэвхжин өрнөж байгаа хөдөлгөөнийг нухчин дарах, хөрш орнууд руу эзлэн түрэмгийлэл хийх Бээжингийн гол зэвсэг болж байна.

1977 онд Энэтхэгийг «Амрита Базар Патрика» сонинд бичсэнээр Төвдийн нутагт байрлуулсан 600—2500 милийн радиусын алсын тусгалтай пуужинт цөмийн төхөөрөмжүүд шаардлагатай цагт Энэтхэг, Афганистаны эсрэг тавихад бэлэн байдалд байна<sup>3</sup> гэжээ. Бээжингийн маоист эрх баригчид өнөөдөр элдэв эргэлзээ төрүүлсэн «хамтын ажиллагаа» гэгчийн үндсэн дээр хөрш зэргэлдээ орнуудаа өөрийн цэрэг дайны бэлтгэлд татан оруулах оролдлого хийж байна. Тухайлбал, «хамтын ажиллагаа»-ны үндсэн дээр 60-аад оны дундуур Лхас, Катманду хоёрын хооронд, дараа нь 1975 онд БНХАУ-ын хүсэлтээр Балба, БНХАУ-ын хооронд Похара-Сурк хэтийн засмал замуудыг барихаар болжээ. Бээжин дээрх замуудыг хөрш зэргэлдээ орнууддаа, юуны өмнө Энэтхэгт шахалт хавчилт үзүүлэх зорилгодоо ашиглаж байна.

Хятад Төвдийн нутгаас Балбад өгч оронд нь авсан Балба, Энэтхэгийн хил залгаа нутагт цэргийн барилга байгууламж барьж байгаа нь төвдийн

<sup>1</sup>Жэньминь жибао, 1975. IX. 11

<sup>2</sup>Shashi Bhushan; "China on the way to Fascism". New Delhi, 1975. p. 153

<sup>3</sup>Амрита Базар Патрика. 1977. II. 18.

зүгээс энэтхэгт даралт шахалт үзүүлэх гэсэн бас нэг санаархал юм. Хэдийгээр хятад энэтхэгтэй харилцаагаа сайжруулах хүсэлтэй байгаа тухайгаа олонтаа ярих боловч Нага, Мизо зэрэг омгийнхон амьдардаг Энэтхэгийн зүүн хойт хил дээр өдөөн хатгалга удаа дараа явуулж байгаа нь өнөөгийн хягадын удирдлагын хоёр нүүртэй бодлогын тодорхой жишээ юм. «Хиндустан таймс» сонин мэдээлсэнээр одоо Энэтхэгийн хилийн дагуу зэвсэглэсэн мянга орчим дээрэмчид хорлон сүйтгэх үйл ажиллагаагаа явуулж тэд хятадаас төвдөөр дамжуулан их хэмжээний зэр зэвсэг, хүнсний зүйлийг авчирч байна.

Ийнхүү Бээжин Энэтхэгийн хил дээр байнгын түгшүүртэй байдал буй болгохыг эрмэлзэж байна. Мөн Энэтхэг, Сикхим, Бирм-Балбын харилцаанд хөндлөнгөөс оролцох бодлогоо Бээжин урьдын адил үргэлжлүүлж буй тухай гадаадын мэдээлэх агентлагууд цохон тэмдэглэж байна. 1962 оны түрэмгийллээр эзлэн авсан Энэтхэгийн ихээхэн хэмжээний нутгийг хятад энэтхэгт буцааж өгөх хүсэлгүй байна. Харин ч Хятад Энэтхэгээс булаан эзлэсэн Кашмирын районы нутгийг Өмнөд Азийн орнуудын эсрэг эзлэн түрэмгийлэх бодлогодоо ашиглаж байна. Кашмирын районд стратегийн чухал зам тавьж 1978 оны 6-р сард нээсэн явдал үүнийг гэрчилж байна. Хятадын тавьсан Каракорумын зам дайран өнгөрч байгаа Кашмирын нутгийн хэсэг нь 1962 онд Хятадаас Энэтхэгийн эсрэг явуулсан түрэмгийлэл хүртэл Энэтхэгийн нутаг байсан бөгөөд «Азад Кашмир» хэмээн нэрлэж буй Кашмирын нутгийн энэ хэсэг нь өнөөдөр Пакистаны хяналтанд байгаа юм. Энэтхэгийн хэвлэлд мэдээлж байгаагаар дээрх Каракорумын 800 км замыг Бээжин Энэтхэг-Пакистаны хооронд яс хаях, Пакистанд цэрэг зэвсэг нийлүүлэх стратегийн зорилгоор барьсан байна. Хятад Каракорумын замыг тавихад 600 сая доллар заржээ<sup>1</sup>. Мөн түүнчлэн БНААУ-тай хиллэдэг Пакистаны нутагт өнөөдөр болж буй хэрэг явдал дээрх замууд стратегийн зориулалттай баригдсан гэдгийг нотолж байгаа юм. «Правда» сонинд «Синьцзянаас Пакистанаар дайруулан тавьсан засмал замыг Пакистаны нутгаас Афганистанд хятадын цэргийн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хорлон сүйтгэх, хагалан бутаргах үйл ажиллагааг зохион явуулах, мөн суртал ухуулгын материал, зэр зэвсэг, сум хэрэглэл их хэмжээгээр оруулахад өргөн ашиглаж байгаа тухай бичиж байна».<sup>2</sup>

Бээжин төвд, синьцзяны нутагт цэргийн барилга байгууламж, стратегийн болон бусад төрлийн зам барьж байгаа нь хятадаас энэтхэгийн хилийн дагуу үтэр богино хугацаанд 36 дивиз бөөгнөрүүлэх өргөн боломж олж авч байгаа юм.<sup>3</sup> Сүүлийн үед Бээжин хөрш орнуудын байгалийн баялагт хүрэх асуудалд ихээхэн ач холбогдол өгч байна. Ийм алхам нь Бээжингийн булаан эзлэх бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг нь болж байгаа юм. Каракорумын зам дагуу нефть, байгалийн хийн нөөц нээж илрүүлсэн нь тэдний анхаарлыг зүй ёсоор татаж байна. 1978 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Гэн Бяо Пакистанд албан айлчлалтаар очиж Каракорумын замыг нээх ёслолд оролцохдоо Каракорумын байгалийн баялгийг хятадад ашиглуулахыг Пакистанаас шаардаж байжээ. Кашмир дахь Гильгитын районд олдсон төмрийн хүдэр, зэс молибден, алт, үнэт чулуу зэрэг байгалийн баялаг Бээжингийн анхаарлыг их татаж байгаа юм. Үүнтэй холбогдуулан Энэтхэгийн олон нийтийн зүтгэлтэн Ш. Бхушан «Кашмирын талаар хятадын бодлого нь Заирын Шаба мужийн талаархи империалистуудын бодлого, түрэмгийлэн булаан авсан

<sup>1</sup>Shashi Bhushan, "Karakorum Road Dominationistic Conspiracy of China in Kashmir" New Delhi, 1978, p. 3

<sup>2</sup>«Правда», 1979. 4-р сар.

<sup>3</sup>Shashi Bhushan, Op., Cit, p., 5.

Арабын нутаг дахь Израилийн булаан эзлэгчдийн үйл ажиллагааг санагдуулж байна»<sup>1</sup> гэж бичсэн байна.

«Дөрвөн шинэчлэлт» хэмээх бодлогоо хэрэгжүүлж хятадыг хүчирхэг армитай их гүрэн болгон хувиргахад Төвдийн автономит районыг цэрэгжүүлэх, түүний байгалийн баялаг нөөц, хүн хүчийг иж бүрэн ашиглах явдал Бээжингийнхэнд онцгой ач холбогдолтой байна. Чухамхүү энэ зорилгоор сүүлийн жилүүдэд Бээжин Төвдийн талаар явуулах бодлогодоо «залруулга» хийж байгаа юм. Тухайлбал, Төвдийн удирдагчдын нэг Банчин-эрдэнийг «урьдын гаргасан алдаа буруугаа хүлээсэн» гэж зарлан албан тушаалд нь дэвшүүлэн тавих шийдвэр гаргав.

Далай лам болон гадаадад дүрвэж гарсан Төвдийн дүрвэгсдэд хандаж эх орондоо буцаж ирэхийг Бээжингээс уриалан, үүнтэй холбогдуулан саяхан Лхасад дүрвэгсдийг хүлээн авах тусгай байгууллага буй болгосон байна.

1959 оны Төвдийн бослогод оролцсон хэргээр шийтгэгдэж шорон гянданд хоригдож байсан 6 мянга гаруй улс төрийн хоригдлуудыг суллахаар зарлажээ.

Цаашилбал өнөөдөр Төвдөд зарим нэг сүм хийдүүд ажиллаж эхлэсэн бөгөөд лам нарт нь ажлын бус цагаар хурал номын ажлаа явуулахыг зөвшөөрсөн байна<sup>2</sup>.

Гэвч Төвдийн талаар Бээжингийн бодлогод оруулсан эдгээр «залруулга» нь өнгөцхөн харахад энэрэнгүй мэт боловч угтаа Бээжингийн эрх баригчдын ээлжит заль мэх гэдэг нь бүгдэд илэрхий юм. Чухамдаа Бээжингийн энэ энэрэнгүй санааны цаана аанай л нөгөө их хан үндэстний жанжлах санаархал оршиж байгаа юм. Өнөөдөр Бээжингийн удирдлага улс түмний энх тайван, аюулгүй байдалд аюултай дайн түрэмгийллийн бодлого явуулж, бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс бүдүүлгээр оролцсоор байна.«Вьетнамд итгэл эвдэж халдан довтолж, хилийн ойролцоо байнга зэвсэг хангинуулж байгаа нь хятад улс бага дунд зэргийн улсуудыг «хамгаалагч» мэтээр ярьдаг хуурамч домгийг бүрэн няцаалаа, Түүгээр үл барам хятадын эрх баригч бүлгийнхэн БНСВУ, Кампучи, Афганистан, Энэтхэг зэрэг Азийн бусад орны эсрэг одоо хүртэл хорт явууллагаа улам хүчтэй болгосоор байна».<sup>3</sup>

Дэлхийн социализм, олон улсын коммунист ажилчны болоод үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг дэлхийд жанжлах бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор Бээжингийн удирдлага империализмын хамгийн харгис хүчинтэй нягт холбоо тогтоохыг онцгой ач холбогдолтой гэж үзэж байгаа юм. Бээжин АНУ болон бусад империалист гүрнүүдтэй улам ойртон сүлбэлдэж байгаа нь энхийг эрхэмлэгч улс орнуудын засгийн газар, ард түмэн, нэн ялангуяа Өмнөд болоод Зүүн Өмнөд Азийн орнуудын ард түмний сэтгэл санааг түгшүүлж байгаа юм. Сүүлийн үед Америк-хятадын страткегичид Энэтхэгийг өөрийн бодлогод татан оруулах талаар шинэ арга замыг эрж хайн энэ зорилгодоо хүрэхийн тулд элдэв заль мэх, хоосон амлалт ч хийж байна. Тэд янз бүрийн хэлбэрийн тусламж дэмжлэгийг Энэтхэгт амлаж байна. Гэвч өнөөдөр тэдний зорилго, үйл ажиллагаа Азийн ард түмэнд хэзээ хэзээнээс тодорхой болж байна.

Хятадын эрх баригчдын хоёр нүүрт бодлогыг илчлэн Энэтхэгийн Үндэсний Конгресс (И) намын дарга хатагтай И. Ганди саяхан хийсэн нэгэн мэдэгдэлдээ: «Хятадын эзлэн түрэмгийлэгчид эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг задлан бутаргахыг санаархаж байна. Хятад Өмнөд ба Зүүн өмнөд Азийн орнуудыг өөрийн бодлогод татан оруулах санаархлын үүднээс Бээ-

<sup>1</sup>Ibid. p. 6.

<sup>2</sup>ИБАС (1977—78).

<sup>3</sup>МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр н. Ю. Цэдэнбалын хэлсэн үг. «Үнэн», 1979. IV. 26.

жин-Вашингтон-Токиогийн гурвын холбоог тогтоох оролдлого хийж байна»<sup>1</sup> гэжээ.

Өнөөдөр хятадын удирдлага хятад-энэтхэгийн хоорондын газар нутгийн маргаантай асуудлыг «нааштайгаар» зохицуулж болох юм гэж Энэтхэгт тал засч байгаа бөгөөд Энэтхэгтэй харилцаагаа «хэвийн» болгох оролдлого хийхдээ янз бүрийн хэмжээний элч төлөөлөгчийг Делид хойно хойноос нь илгээж байна. Хятад Энэтхэгийн хилийн асуудлыг Энэтхэгт «буулт» хийх замаар зохицуулахад бэлэн байгаага тэд амлаж, ялангуяа Кашмирын асуудлаар урьд нь баримталж байсан байр сууриа «зөөлрүүлэх» замаар энэ оронтой худалдаа эдийн засгийн өргөн харилцаа тогтоох сонирхолтой байгаага мэдэгдэх боллоо. Гэвч Энэтхэгийн олон нийт хятадын удирдагчдын далдын санааг аль эртнээс сайн мэдэх тул Бээжингийн дээрх санаачлагыг урьдаас төлөвлөн боловсруулсан арга заль гэж үзэж байгаа юм. Ялангуяа сүүлийн үед Бээжингийн эрх баригчдаас явуулж байгаа үйл ажиллагаа нь хятад Энэтхэгтэй харилцаагаа тэгш эрх, жинхэнэ найрсаг хөршийн зарчим дээр хэвийн болгох гэсэн чин эрмэлзлэл өвөрлөхөөсөө харин Энэтхэгээс бусад улс орнууд, юуны өмнө ЗХУ-тай тогтоосон уламжлалт харилцааг хохироох замаар Хятад-Энэтхэгийн харилцааг хэвийн болгохыг санал болгож байгааг энэтхэг сайн мэдэж байгаа юм. Тиймээс ч Бээжингийн жанжлах үзэлтнүүдийн энэ санаархлыг Энэтхэг шийдвэртэй няцааж улмаар ЗХУ болон дэлхийн бусад социалист орнуудтай найрамдалт харилцаагаа цаашид улам бэхжүүлэхийг эрмэлзэж байна. Харин ч Энэтхэг улс Бээжингийн эрх баригчдын явуулж байгаа түрэмгийлэл, цэрэг дайны бэлтгэлээс хэзээ хэзээнээс илүү болгоомжлон сэрэмжилж байгаа нь Энэтхэгийн Батлан хамгаалах яамны сайд агсан Ж. Рамын хийсэн мэдэгдлээс илт байна. Тэрээр хэлэхдээ: Хятадууд Гималайн зүгээс хуурай зам болон агаараар Энэтхэгийн нутагт цөмрөн орж ирэхээс Энэтхэг улс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авч байна» гэжээ.

Бээжингийн удирдагчид Төвдийг цэрэгжүүлэн түүнийг хөрш зэргэлдээ орнуудын эсрэг булаан эзлэх бодлогодоо түшиц газар болгож байгаа нь зөвхөн Төвдийн автономит районы улс төр, эдийн засаг, соёлын амьдралд их хэмжээний хор хохирол учруулаад зогсохгүй улмаар Энэтхэгийг салбар тивийн орнуудын ард түмний энх тайван, аюулгүй байдалд бодит аюул занал учруулж байгаа юм.

**Д. Пурэв**

## МИЛИТАРИЗАЦИЯ ТИБЕТА И ЭКСПАНСИОНИСТСКАЯ ПОЛИТИКА МАОИСТОВ В ОТНОШЕНИИ СОСЕДНИХ С НИМ СТРАН

### **Р е з ю м е**

В статье анализируются великодержавная шовинистическая политика Пекина в отношении Тибетского автономного района, роль милитаризации Тибета в осуществлении экспансионистской политики маоистов в соседних с Тибетом странах.

Сегодня ни для кого не секрет, что нынешние пекинские правители усиленно проводят антисоциалистический курс на милитаризацию всего Ки-

<sup>1</sup> Сообщения «ТАСС» 1979. V. 13.

тая. В соответствии с этой политикой в Тибетском автономном районе (ТАР), как и в других национальных районах Китая, широко проводится милитаризация общественной жизни и его экономики.

Тибету давно отводится особое внимание, как важному району в военно-стратегическом отношении. В настоящее время Тибет превращен в военный плацдарм для осуществления экспансионистских планов в странах, прежде всего, непосредственно граничащих с Тибетом. Автор подчеркивает, что именно с этим связаны насильственная китаизация коренного населения Тибета путем массового переселения туда китайцев и территориального расчленения Тибета.

Начиная с конца 50-х годов Пекин стал открыто отходить от принципов «Панча Шила». Он крайне обостряет отношения с Индией- В 1962 г. Китай захватил 36 тыс. кв. км индийской территории. Сегодня эта территория оккупирована китайцами. А недавно открытое здесь Каракорумское шоссе свидетельствует о том, что Китай начал осуществлять план по эксплуатации захваченной территории в целях использования ее для дальнейшей экспансии стран этого региона. Пекин продолжает вмешиваться в индийской-сикхимские и бирманско-непальские отношения с целью создать очаги напряженности на индийской границе.

Сегодняшний Китай имеет территориальные претензии ко всем странам, граничащим с ним, кроме того, жадные устремления китайских лидеров в отношении природных богатств соседних государств, несомненно, вызывает глубокое беспокойство у народов этих стран.

Наращивание военного потенциала Китая и усиление военных приготовлений в Тибете маоистами ставит перед соседними с ним странами, прежде всего, Индией, серьезные проблемы.

Таким образом, заключает автор, политика Пекина по милитаризации Тибета и превращению его в плацдарм для экспансии против стран, граничащих с Тибетом, не только причиняет большой ущерб политической, экономической и культурной жизни этого автономного района, но и создает реальную угрозу миру и безопасности народов стран Индустанского полуострова.